



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 4 сарын 04 өдөр

Дугаар 126

Улаанбаатар хот

Г Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа Г
эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулахыг
зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-ын 5.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Гэр даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 972,000,000.00 /есөн зуун далан хоёр сая/ төгрөгөөр нэмэгдүүлж, хувьцаа эзэмшигчдийн бүтцийг энэхүү тогтоолын хавсралтад дурдсанаар өөрчлөхийг зөвшөөрсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Гэр даатгал” ХХК /Э.Мөнгөнзул/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2018 оны...4... сарын...өдрийн
...126 тоот тогтоолын хавсралт



“ТЭР ДААТГАЛ” ХХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ,
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эхний үлдэгдэл			Өөрчлөлт			Эцсийн үлдэгдэл		
		Хувьцаан ы тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 1000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь	Хувьцаа ны тоо ширхэг	Нэмэгдсэн	Хорогдсон	Хувьцаан ы тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 1000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь
1	“Кэй Эйч Кэй” ХХК	3,850,000	3,850,000,000.00	100%	972,000	972,000,000.00		4,822,000	4,822,000,000.00	100%
	Нийт	3,850,000	3,850,000,000.00	100%	972,000	972,000,000.00		4,822,000	4,822,000,000.00	100%